



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ



# ЧУХАЛ СЭДЭВ

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТЭМДЭГЛЭЛ

2022 ОНЫ 12 ДУГААР САР

“ЭРҮҮДЭН ШҮҮХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ МЕХАНИЗМ” ТЭМДЭГЛЭЛ

## АРГА ЗҮЙ

Нээлттэй Нийгэм Форум нь эрх зүйн шинэчлэлийн үйл явцыг бодлогын хэлэлцүүлэг, судалгаагаар дэмжиж ажиллахыг зорьдог билээ. Энэ хүрээнд хүний эрхэд суурилсан шударга процесс бүхий эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор “Эрүүгийн процесс ба Хүний эрх” цуврал хэлэлцүүлгийг эхлүүллээ. Эдгээр хэлэлцүүлэг нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэд хэдэн хуулийн төслийг УИХ хэлэлцэж байгаа үетэй давхцаж буйгаараа онцлог юм. Цуврал хэлэлцүүлгийн зорилго эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шатанд тулгамдаж буй хүний эрхийн асуудлыг хөндөхөд оршиж байгаа бөгөөд хэлэлцүүлгийг ХЭҮК, ХЗДХЯ, МХХ, МӨХ-той хамтран зохион байгуулж байгаа билээ. Энэ удаагийн хэлэлцүүлэг шинэ тутам бий болсон эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмын хүрээнд өрнөсөн бөгөөд түүний тэмдэглэлийг сийрүүлэн Та бүхэнд хүргэж байгаадаа баяртай байна.

## ЭРҮҮДЭН ШҮҮХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ МЕХАНИЗМ

### ЕРӨНХИЙ ТОЙМ

Эрүүгийн эрх зүйн шинэчлэл 1993 оноос эхэлж, энэ хугацаанд хоёр удаа эрүүгийн хууль тогтоомжийг шинэчлэн найруулж баталсан бөгөөд холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажил үргэлжилсээр байна. Энэхүү шинэчлэлийн зорилт бол хүний эрхэд нийцсэн шударга процесс бүхий эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бэхжүүлэх явдал билээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тэвчиж үл болох хамгийн ноцтой зөрчил бол эрүүдэн шүүх, хүнлэг бус харьцаанаас ангид байх эрхийн зөрчил юм. Тиймээс эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний механизм шинэ тутам байгуулагдсантай холбогдуулан энэ сэдвийн хүрээнд хэлэлцэж, зарим дүгнэлт хийлээ.

## ЭРҮҮДЭН ШҮҮХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ МЕХАНИЗМ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт болон Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар эрүү шүүлт, хүнлэг бус, хэрцгий доромж хандлагаас ангид байх эрх бол туйлын эрх буюу абсолют эрх юм. Олон улсын хүний эрхийн эрх зүйд туйлын эрх маш цөөн. Эрүү шүүлт нь хүний нэр төр, эрхэм чанарыг ноцтой үгүйсгэдэг тул эрүү шүүлтээс ангид байх эрхийг хүний эрхийн эрх зүйд туйлын эрх хэмээн үздэг. Өөрөөр хэлбэл, ямар нэгэн зүй ёсны зорилго, шалтгаан, өөр юу ч байхыг үл харгалзан төрөөс энэ эрхэд халдахыг хориглоно.

Хүн төрөлхтний түүхийн олон мянган жилийн турш буюу өнөө хүртэлх дийлэнх хугацаанд ноёлон хэрэгжиж ирсэн нэг зүйл бол гэмт хэрэг илрүүлэх, ял эдлүүлэх зэрэг тодорхой зорилгод хүрэхийн тулд төр, төрийн байгууллага, тэдгээрийн төлөөлөгчдөөс хүний бие махбод, эсвэл сэтгэл санаанд хүчтэй шаналал зовлон учруулж байсан явдал юм. Тухайлбал, тодорхой зорилгод хүрэхийн тулд хүнийг олон хоног уурын зууханд хорьсон, тамхины цогоор түлсэн, цохиж зодсон гэх мэт хэрэг манайд гарсан тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж байсан. НҮБ-ын энэ асуудлыг хариуцсан тусгай илтгэгч Манфред Новак 2005 онд Монголд ажилласан тайландаа “Эрүү шүүлт хавтгайрсан байна” гэсэн дүгнэлт хийсэн. Хүний эрхийн Үндэсний Комиссын бараг жил бүрийн тайланд энэ асуудал тусаж ирсэн. Тиймээс эрүү шүүлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр цөөнгүй ажил хийснээс дурдвал эрүүгийн хууль тогтоомжийг сайжруулахад анхаарч, НҮБ-ын Эрүүдэн шүүлтийн эсрэг конвенцын нэмэлт протоколд нэгдэж орсон явдал юм. Энэ нь өмнө хэлсэнчлэн эрүүдэн шүүлтээс ангид байх эрх - туйлын эрх бөгөөд Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д зааснаар “төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх” үүргийн хүрээнд дээрх ажлууд хийгдсэн.

Хэзээ нэгэн цагт, хэн нэгэн хүн ороод ирж магадгүй гэсэн шалтгаанаар тухайн байгууллагууд зөрчил гаргахгүй байх үндэс бий болно гэсэн үзэл санаанд тулгуурлан урьдчилан сэргийлэх механизм бий болсон. Учир нь нэгэнт эрүүдэн шүүгдсэний дараа хүн амь насаа алдаж, эрүүл мэндэд нь хохирол учрах зэргээр маш хүнд нөхцөл байдал тулгардаг тул урьдчилан сэргийлэх нь илүү өндөр үр дүнтэй, зардал багатай механизм гэж үзсэн хэрэг юм.

## ЭРҮҮДЭН ШҮҮХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ

### МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУХАЙ ХУУЛЬ

#### 33 дугаар зүйл

33.1.1. аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлах зорилгоор тогтмол хяналт шинжилгээ хийх;

Тайлбар: Энэ хуульд заасан “бүх газарт” гэдэгт хорих байгууллага, цагдан хорих анги, түр болон албадан саатуулах газар, сэтгэцийн эрүүл мэндийн төв, хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон ахмадын асрамжийн газар, сургуулийн дотуур байр, албадан эмчилгээний байр, дүрвэгсдийн байр, цэргийн сахилгын байр, хилийн шалган нэвтрүүлэх боомт дахь түр саатуулах болон хамгаалах байрыг ойлгоно.

Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх механизм нь аливаа хэлбэрээр эрх чөлөө нь хязгаарлагдсан, өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт нэвтэрч, гэнэтийн, тогтмол хяналт шинжилгээ хийх гол чиг үүрэгтэй. Энэ чиглэлээр Нээлттэй Нийгэм Форумгаас гарын авлага гаргасан бөгөөд түүнд уг механизмын тухай нэлээд дэлгэрэнгүй тусгасан.<sup>1</sup> Бид эрүү шүүлтийг хорих газар, эсвэл цагдан хорих, саатуулах байранд л үйлдэгддэг хэмээн боддог. Гэтэл хүүхдийн болон ахмадын асрамж, халамжийн газар, сэтгэцийн эрүүл мэндийн байгууллага, цэргийн анги, нэгтгэл зэрэг олон объект үүнд хамаардаг. Тиймээс энэ механизмын хяналт шинжилгээ хийх газар нь 21 аймаг, 330 гаруй сум, нийслэл, 9 дүүрэгт оршин байх тул маш өргөн цар хүрээтэй ажиллахыг шаардана. Цаг хугацааны хувьд ч ажлын 8 цагаар хязгаарлагдах ажил биш юм.

<sup>1</sup> Б.Хишигсайхан, Г.Агар-Эрдэнэ. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа. Нээлттэй Нийгэм Форум, УБ., 2021, <https://forum.mn/product/152603>

Учир нь гэнэтийн шалгалт хийхийн тулд шөнийн цагаар ч хаалга тогшоод л орох хэрэг гарна.

Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх механизм бол эрүүдэн шүүгдсэн тухай гомдлын мөрөөр явдаг биш, болзошгүй нөхцөлөөс урьдчилан сэргийлдэг механизм юм. Гомдлын мөрөөр явах газар нь Хүний эрхийн Үндэсний Комисс бөгөөд түүний 6 гишүүн байна. Нөгөө талаасаа мөн зөвхөн хяналт шинжилгээ хийхийн зэрэгцээ хууль тогтоомжид өөрт нь ийм зөрчил гаргаж болзошгүй нөхцөл байдал байна гэж харвал үүнийг засаж залруулахын төлөө ажиллах ёстой механизм юм.

Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь бие даасан байх, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай чадавх бүхий мэргэшсэн байх, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах нөөцтэй байх гэсэн гурван асуудал зөв голдирлоороо явж байж механизм зөв бүрдэнэ. Манай улсын хувьд онцлох зүйл бол эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх механизмыг шүүх эрх мэдлийн, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын дэргэд биш, Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд байгуулсан нь зөв, зүйтэй алхам болсон юм. Мөн уг асуудал эрхэлсэн гишүүнийг нээлттэй, ил тод, олон нийтийн оролцоотой сонгон шалгаруулж томилсон нь тун чухал алхам билээ.

Цаашид анхаарах нэг чухал асуудал бол Хүний эрхийн Үндэсний Комисс нь эрүү шүүлттэй холбоотой гомдол, мэдээллийг шалгаж шийдвэрлэдэг чиг үүргээс бүрэн тусдаа байх асуудал юм. Учир нь эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний механизм нь эрүү шүүлт гарсны дараа шалгадаг биш, харин гарч болзошгүй нөхцөл байдлуудыг урьдчилан харж, тогтмол хяналт шинжилгээ хийх замаар асуудлыг засаад явах ёстой механизм билээ.

Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх чиг үүргээ хэрэгжүүлэхэд чадавх бүхий, мэргэшсэн, хангалттай хүний нөөц онцгой үүрэгтэй. Мэргэшсэн байх гэдэг ойлголтын хүрээнд “Уг нэгж ямар бүрэлдэхүүнтэй байх ёстой вэ?” гэсэн асуулт урган гарч ирнэ. Хэрэв дандаа хуульчдаас бүрдвэл буруудна, учир нь эрүүдэн шүүж болзошгүй асуудлыг олж тогтооход сэтгэл зүйчид, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн оролцоо чухал. Тиймээс нэгжийн бүрэлдэхүүнийг зөв бүрдүүлэх нь тус механизмын үр нөлөөтэй байдалд чухал нөлөөтэй.

Монгол Улс эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизм байгуулах эрх зүйн үндсийг тогтоосон нь зөвхөн эхлэл юм. Харин механизмыг анхнаас нь олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн байгуулж, ажиллуулах нь маш чухал. Анхны суурь жишиг буруу тавигдвал дараа нь олон арван жил засах боломжгүй нөхцөл байдал үүсдэгийг бид олон институтийн гашуун туршлагаас харж болно.

Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2-т заасан нэгжийн дарга, ажилтан бол зөвхөн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд туслах чиг үүрэгтэй гэж заасан нь энэ нэгж ХЭҮК-оос тусдаа чиг үүрэгтэй гэдгийг тодотгож буй хэрэг юм. Хараат бус байдлыг зохицуулсан бусад заалтыг дурдвал тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хараат бус, бие даасан, цогц байна, 31 дүгээр зүйлийн 31.2-т “Комиссын болон бусад албан тушаалтан эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх, оролцохыг хориглоно” гэх зэргээр зохицуулсан. Зарим хүмүүс эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнийг комиссын 7 дахь гишүүн гэж ойлгож, яриад байгаа нь ташаа ойлголт юм. Нэг ёсондоо хараат бус институтийн дэргэд хараат бус, өөр нэг институт байгуулсан гэдгийг сайн ойлгох нь зүйтэй. Төсвийн хувьд ч мөн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсөв нь ХЭҮК-ын төсвөөс тусдаа, бие даасан, хангалттай хэмжээний байх ёстой.

Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд жил бүр тайлан мэдээлэл, санал зөвлөмж оруулж байх ёстой. Энэ хүрээндээ магадгүй, анхны оруулах асуудал бол хуульд болохгүй байгаа асуудлыг засах, залруулах зөвлөмжүүд байх боломжтой. Нөгөө талаар хүний эрхийн үндэсний байгууллагууд дотроо эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх энэ алба нь шууд харьяалж, хамтарч ажилладаг олон улсын байгууллагатай бөгөөд энэ нь НҮБ-ын Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх дэд хороо юм. Тэгэхээр тус дэд хороотой хамтран ажиллах замаар энэ хуулийг зөвөөр тайлбарлан хэрэглэж, зөв жишиг тогтоох нь чухал.

## ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

- \* Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын нэмэлт протоколд бүрэн нийцсэн байдлаар ажиллах боломж, нөхцөл бүрдүүлэх, чадавхыг нь бэхжүүлэх;
- \* Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмын талаарх төр, төрийн бус байгууллага, иргэдийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулах.

## ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ОРОЛЦОГЧДЫН НЭРС

1. Б.Алтантуяа - Монголын Эмнести Интернэшнл ТББ-ын Гүйцэтгэх захирал
2. Ч.Гантуяа - МХХ-ны Эрүүгийн эрх зүйн хорооны гишүүн, хуульч
3. Ц.Лхагвацэнд - ХЗДХЯ, Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн
4. О.Мөнхсайхан - МУИС-ийн Хууль зүйн сургууль, хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор
5. Г.Наранбаатар - МХХ-ны зөвлөлийн гишүүн, өмгөөлөгч, хууль зүйн ухааны доктор (Ph.D), дэд профессор
6. Р.Оюунбадам - ХЗҮХ-гийн зөвлөх, хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор
7. Г.Оюунболд - МХХ, Эрүүгийн эрхзүйн хорооны тэргүүн
8. Я.Цэлмэн - ХЭҮК, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, хууль зүйн ухааны доктор (Ph.D)
9. Б.Энхболд - ХЭҮК-ын гишүүн, хууль зүйн ухааны доктор (Ph.D), дэд профессор
10. Г.Эрдэнэбат - Хуульч

